



НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН
ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
И-мэйл: contact@afccp.gov.mn, Вэбсайт: www.afccp.gov.mn

2020.02.05 № 1/140
танай _____-ны № _____-т

Тендер шалгаруулалтын тухай

Танай газраас 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зарласан “Даатгалын үйлчилгээ үзүүлэх тухай” НЦГ/202001001 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт холбогдох гомдлыг “Мөнх даатгал” ХХК-иас тус газарт ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55.4-т заасны дагуу гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендерийн шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг, тендер шалгаруулалтын материал авах, нээлт хийх үйл ажиллагааг түр түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Уг тендер шалгаруулалттай холбоотой холбогдох тайлбар, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл болон тус тендерийн баримт бичгийг нотлох баримтын шаардлага хангуулан 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА

Б.ЛХАГВА

Амьдралын болон хуульч
хурлын (НБЗ дотроо)

0000507